

МОНГОЛЧУУДЫН БАЙГУУЛСАН ГҮРЭНИЙ ТӨРИЙН БОДЛОГЫН
ТАЛААРХИ ТҮҮХЭЧ БУС ХҮНИЙ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Ц. Шагдарсүрэн*

0. Оршил болгоход ...
1. Шашин сурталын тухайд
2. Бичиг үсэгийн тухайд
3. Гадаадын эрдэмтэд хэрхэн дүгнэсэн байдаг вэ?
Хавсралт 1, 2.

0. Дэлхийн олон их гүрэний түүхийг үзвэл гүрэн улсаа гол төлөв цэрэг зэвсэгийн хүчээр байгуулсан байх бөгөөд дараа нь эзлэн авсан олон үндэстнийг их гүрэний нэгэн дээвэр дор эмхилэн нэгтгэх нь эзлэн авахаас ч илүү нарийн бодлого шаарддаг болох нь харагдана. Энэ нь зөвхөн Их Гүрэнийг байгуулах тухайд ч төдийгүй “хүний эрхийг эдлүүлнэ, засан төвхнүүлнэ, энхийг сахиулна, ардчилалыг буй болгоно, дарлал мөлжлөгөөс чөлөөлнө, баян чинээлэг болгоно” гэх зэрэг сайхан үг хэлж бусад улс орон руу цэрэглэн дайлсаны дараа хэсэг зуур ч болов тогтоон барих үед ч мөн хамаатай болохыг орчин үеийн олон улсын цэрэг зэвсэг хэрэглэсэн үйл явдал харуулсаар бөлгөө. Сэтгэлд нийцтэй сонсогдох дээрхи мэт сайхан үгийн цаана, ганц нэг жишээ хэлэхэд: “энхийг сахиулагчид” нь энгийн номхон иргэд, хүүхэд эмэгтэйчүүдийг алж талсан сураг чимээ тасрахгүй гарсаар байгаа, мөн “хүний эрх” хэмээн хамгийн их ярьж, бусад улс орныг үүгээрээ буруутгадаг Их гүрэнүүд өөрсөдөө нөгөө “хүний эрх”-ээ хэрхэн зөрчиж, сэжиглэсэн хүнээ хүч хэрэглэн махлан яргалаж, эрүүдэн шүүсээр байгаа нь чухамхүү тэр “сайхан” үгийн мөн чанарыг нь харуулсаар байгаа боловч Баян хүн таван хаанд нүүртэй гэгчээр дэлхийгээрээ үл мэдэгч болон амаа хамхисаар бөлгөө. Түүхийг сөхөн үзвэл чухам бүхий л үеийн туршид олонхи их гүрэн болон эзлэсэн улс нь эзлэгдсэн бусад үндэстэн, бусад орныг хэл бичиг, шашин суртал, соёл уламжлалдаа уусган оруулж, үндэснийхи нь тэдгээр зүйлийг үгүй хийж, өөрийн эрх ашигыг явуулдаг нь яв явсаар самууны үүдийг нээхэд арга буюу хүргэдэг байна. Ямар ч баян чинээлэг улс өөрт ашиггүй байхад бусадын сайн сайханы төлөө цэрэг зэвсэг болж, үй олон хүнээ дайн самуунд алдаж, үлэмжхэн хөрөнгө мөнгөө зарна гэж байх уу, сайтар бодож үзэгтүн. Монголчууд “морин дээрээс улс орныг эзлэх амархан, харин мориноосоо буугаад улс орныг төвхнүүлэх нь хэцүү” гэдэг байсан нь ийм явдал байдагийг сайтар ухаарч их улс даяар “гар газар, хөл хөсөр талбиулж”, “эрийг үл зовоон, агтыг үл хөлөргөн” амар жимэр аж төрөхөд онцгой анхаарч байсан гэдгийг биднээс түрүүн гадаадын эрдэмтэд ажин харж “*Pax Mongolica ~ Pax Mongolorum*” хэмээх бодот

* МУИС-ийн МХСС-ийн багш, ШУ-ны доктор, профессор

ойлголт байсныг удаа дараа гарган тавьсаар байгаа тул үүнийг монгол хүний сэтгэлийн хөөрлөөр гаргасан зүйл гэж биднийг буруутгахаас хамгаалах нь дамжиггүй буй заа. Ийнхүү мориноосоо буугаад их төр улсыг амар жимэр төвхнүүлэх ганц жор байгаагүй, улс улс, үндэстэн үндэстэний аж төрөлд тохирох “хууль” (энэхүү “хууль” гэдэг үг нь энд засаг цааз гэсэн утгаар бус)-иар захиран залж ирсэн ажээ. Наад зах нь монгол угсааны хятаны Елүй Цуу-цай (энэ хүнийг “Монголын нууц товчоон”-ы Цуу мэргэн мөн хэмээн Цэмбэл гүүш бүтээлдээ тэмдэглэсэн нь буй) өмнө газрын олон түмнийг амар жимэр хэрхэн захирах талаар зөвлөснийг энд жишээ татаж болно. Одоо ч гэсэн, аль ч үед эзэн хаан, ерөнхийлөгч, ерөнхий сайд, сайд нарын дэргэд зөвлөгч нар байсаар ирсэн бөгөөд цагийн саалтад зөвлөгч нарын цэц ухаан саарсан байж болох ч эцсийн дүнд шийдвэрийг зөвлөгч биш зөвлүүлэгч нь гаргадаг тул Чингис хааны нэр хүндийг Елүй Цуу-цай буруулсан гэж үзэх үндэсгүй.

Тэгээд ч Монголын их гүрэн болон монгол төрт Юан улсын дотоод гадаад бодлогыг авч үзвэл дээр өгүүлсэн одоогийн их гүрэнийхитэй огт адилгүй, улсынхаа дотоодод төдийгүй бүс нутагтаа урт удаан амар амгаланг буй болгоход “хүний сэтгэлийг олох”, “хоры нь авахаар дуры нь ав” гэдэг өвөрмөц зарчимтай байсныг батлах түүхэн баримт олон буй. Наад зах нь, өнөөгийн олон нийтэд ойлгомжтой болгохын үүднээс эдүгээчлэн буулгаж гэмээ нь “...Та ургууд миний мөн хойно улс иргэнийг хураана гэвэл биеийг нь хураахаас өмнө сэтгэлийг нь хураавал зохино. Сэтгэлийг нь хураах бөгөөс бие нь хаа одох...” хэмээсэн, монголын дөрвөлжин бичгээр үлдэж, Истанбулын номын сангаас олдсон Хубилай хааны зарлиг-гэрээсийг дурдаж болно¹. Монголчуудын байгуулсан Төрийн энэ зарчим нь хоосон үг огт байгаагүй юм. Тэр нь аливаа шашин суртал хийгээд бусад үндэстэний хэл болон бичгийг нь тэгш хүндэтгэх зэргээр илэрч байжээ. Энэ ташрамд тэмдэглэхэд, Юан гүрэний бүрэлдэхүүн дэхи монгол, хятад, төвөд зэрэг бараг бүх үндэстэн өөр өөрийн бичигтэй байсан ч аль нэгийг нь бэлэнчлэн авч хэрэглэлгүй цоо шинэ Дөрвөлжин бичгийг Пагва (1234-1279) ламаар тулгар зохиолгож Улсын бичиг болгосон нь цаанаа улс төрийн нарийн хараатай байсаны баримт бөлгөө. Энэ бүхнийг ч гадаадын нэг бус эрдэмтэн ажин тодруулж Монголын амгалан төр гэсэн утга бүхий *Pax Mongolica* буюу *Pax Mongolorum*, мөн бусад ард түмний хэл бичиг, аж төрөл, шашин суртлыг хүлээн зөвшөөрөх Монголын хүлцэмж (*Language and Writing Tolerance, Life Tolerance or way of life Tolerance, Religious Tolerance*) гэсэн утга бүхий *Mongolian tolerance* гэх зэрэг тусгай нэр томъёог хэрэглэж энэ талаар олон өгүүлэл, ном товхимол хэдийнээ гаргажээ².

¹ O. N. Tuna, J. E. Bosson, (1962), *A Mongolian 'Phags-pa Text and its Turkish Translation in the "Collection of Curiosities"*, - Journal de la Societe Finno-Ougrienne, Tom. 63, pp. 3-16, Helsinki.; Table in 10; L. Ligeti, (1972) *Monuments en écriture 'Phags-pa, Pièce de chancellerie en transcription chinoise* [Monumenta Linguae Mongolicae Collecta III], p. 123; Budapest., 照那斯图, 八思巴字和蒙古语文献, II 文献汇集, 東京外国语大学, 1991, pp. 216-219; Төмөртоогоо, Д. (2002) Монгол дөрвөлжин үсэгийн дурасгалын судалгаа, 66-67-р тал, Улаанбаатар., Жанчив. Ё. (2002) Дөрвөлжин бичгийн монгол дурсгал, II- Monumenta Mongolica, Tomus III, Centre for Mongol Studies, National University of Mongolia, 144-р тал; Улаанбаатар., 呼格吉勒图, 萨如拉, 八思巴字蒙古语文献汇编, 阿尔泰学丛书, 内蒙古教育出版社, 2004 年, pp. § 52, 514-515.

² W. Kotwicz, (1950) *Les Mongols, promoteur de l'idée de paix universelle au debut du XIIIe siècle*, - Rocznik Orientalistyczny, Tom. XVI, Krakow., 1953 – (В. Котвич авгайн төрсөний 100

Монголчууд байгуулсан төр, гүрэн улсаа амар жимэр төвхнүүлэх, дотоод хийгээд гадаад бодлогодоо бусад үндэстэний шашин суртал, хэл болон бичгийн тухайд ямар зарчим баримтлаж ирсэн талаар хэдэн жилийн өмнөөс өөр сэдвийн ташрамд өгүүлсэн, одоо энэхүү өгүүлэлд тэрхүү санаагаа зарим баримтаар нэмэн тодруулахыг зорилоо.

1. Шашин сурталын тухайд:

Юан улсын үед монгол болон дөрвөлжин бичигээр гарсан хаадын бүх зарлигт олон зүйл шашины сүм хийдийг алба гувчуураас чөлөөлөн дархалсан зүйл буй. Үүний үүсэл нь Чингис хаантаны Их монгол улсаас улбаатай бөгөөд тэрхүү чөлөөлсөн зүйлийн хүрээ хязгаар нь яв явсаар Юан гүрэний үед улам өргөн болсоныг удаа дараагийн тэдгээр зарлигаас харж болно. Энэ бол олон үндэстэний олон янзын шашин сурталыг эрх тэгш үзэж, шашин шүтэх эрх мэдэлийг нь чөлөөтэй хангасанаар олон иргэний “*сэтгэлийг олж*” амар амгаланг тогтоох төрийн бодлого байсан гэдэг нь тодорхой харагдана. “*Сэтгэлийг олно*” гэдэг нь зөвхөн нэг талын буюу зөвхөн санаачлагч талын эрх ашигт нийцэх төдийгүй, хэн хэнийх нь эрх ашигт адил нийцэж, нийтээр амар амгалан аж төрөх боломжийг буй болгодог байжээ гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл одоогийн Их гүрэнүүд шиг бусад шашинтаныг өнгө мөнгөөр хуурах, шашины улбаатай соёлын үнэт өвөөр нь буу зэвсэгийнхээ овоо харааг шалгах, бурхан номыг нь булаан авч шатаах зэргээр өөрийн үзэл суртал, шашин номыг хүч түрэн хүлээлгэж байгаагүй гэсэн үг.

Цаг хугацааны хувьд Монгол Төрийн шашины талаархи энэ бодлого нь ямар ч атугай Чингисийн байгуулсан Их Монгол Улсын үеэс хэрэгжсээр ирсэнийг түүхэн баримт харуулдаг. Тухайлбал: Юаны үед монгол бичиг болон дөрвөлжин бичгээр тархаасан хэдэн арван зарлиг цөмөөрөө

...*Чингис ханы, Өгөөдэй хааны, Сэцэн хааны, Өлзийт хааны, Хүлэг хааны, Буянт хааны, Гэгээн хааны, Хутагт хааны, Ринченбал хааны ба хааны зарлигт ...*

гэх мэтээр тоочиж эхлэсэн байдаг нь уг бодлогын түүхэн зам чийрийг гэрчилэж байгаа хэрэг. Тэдгээр олон зарлигийн гол агуулгыг авч үзвэл нийт шашинтаны эрх дархыг улам өргөтгөсөн байдал харагддаг. Тухайлбал:

жилийн ойгоор академич Ринчен багшийнхаа дуртхагсанаар энэ өгүүлэлийн зохиогч уг өгүүлэлийг монголчлон нийтлүүлж билээ: Владислав Котвич, (1974) *XIII зууны эхин үед Монголчууд дэлхий нийтийн энх тайвангийн санааг сэдэж үүсгэсэн нь* // - Хэл зохиол судлал, IX боть, 20-р дэвтэр, 205 - 214 х; Улаанбаатар., Chantal Lemerrier-Quelquejay, (1970) *La paix mongole, Joug tatar ou paix mongol?* Paris.; Grzegorz Leopold Seidler, (1959) *The political doctrine of the Mongols*, - Annales Universitatis Marie-Curie Sklodowska, Vol. VI.7, , pp. 249- 277; Lublin, Polonia., Stuard Legg, (1970/1995) *The Barbarians of Asia*, 350 p. New York., [Арван бөлөг бүхий энэ ном анх *The Heartland* нэрээр гарсан бөгөөд IX бөлөг нь *Pax mongolica* (282-320-р тал) гэдэг нэртэй]; Herbert Franke, *Pax Mongolica*, - Die Mongolen, von W. Heissig, C. C. Müller, (1989) Haus der Kunst München, 22. März bis 28. ss. 54-57; Май., Удо Б. Баркманн, (2003) “*Pax Mongolica*”-ийн талаар эргэцүүлэн бодохуй, - Acta Mongolica, Volume 3 (215), 77-83-р тал, Ulaanbaatar.,

Юан гүрэний дөрвөлжин бичигээрхи эхин үеийн буюу 1276 оны Мангалын зарлигт:

“... Чингис ханы ба... хааны зарлигт тойд, эрхүүд, сэншин дашмад **цан тамгаас бус** аливаа алба гувчуур үл үзэн тэнгэрийг залбирч ерөөл огон атугай хэмээгдэгсэд ажгуу... Эдүгээ-бээр бөгөөс урьдын зарлигийн ёсоор **цан тамгаас бусад** аливаа алба гувчуур үл үзэн тэнгэрийг залбирч ерөөл огон атугай хэмээн ... барьж явах бичиг өгөв...”

хэмээн тэмдэглэсэнээс үзэхүл **цан тамга** буюу газар хийгээд худалдааны татвар авдаг байсан нь харагдана. Харин дараа нь гарсан Хубилай хааны зарлигт:

“...Эдний сүм хийдэд элчин бүү буутугай. Улаа шүүс бүү барьтугай. **Цан тамга бүү өгтүгэй**. Газар, ус, цэцэрлэг, тээрэм юу хээг нь булааж бүү автугай...”

гэж түрүүчийн зарлигаар авдаг байсан **цан тамга** хэмээх албаас чөлөөлж аливаа шашинтаны эрх хэмжээг өргөтгөсөөр иржээ.

Монгол Төр дээрхи бодлогоо хэрэгжүүлэхэд нөгөө талаас нийт шашинтаны эрх ашигийг хөндөж болзошгүй дотоодынхоо хүчин зүйлийг давхар бодолцож, ... харуулын ахлах нярав, даргач, цэрэгийн бүх ноёд, цэрэг ард (*military personnel*³), элч хэн боловч тэднээс **цан тамга**, алба гувчуур авч, улаа шүүс гаргуулах хийгээд адгуус мал хэд ч байсан булааж татаж авах, аяга сав юу хээг хүчээр болон гуйж авах, унаа малаа тэжээлгэх, ... гэх зэрэг хүч түрэмгийлэх бүхий л явдалыг хориглож “...бүү автугай... /...ёсгүй хүч бүү хүргэтүгэй...” хэмээн Зарлиг бүртээ тодлон зааж давхар анхааруулсан байдаг нь тухайн бодлого одоогийнхи шиг **тунхаг төдий зүйл** огт биш байсан гэдгийг бэлхэнээ харуулна.

Үүний дээр аливаа шашины сүм хийдийг элдэв алба татвар, гувчуур зэргээс чөлөөлөхийн хажуугаар тэдний дагаж явбаас зохих хэм хэмжээ, үүргийг нь давхар сануулж

“... эд (сэншинүүд / тойд /...) бас зарлигтан [=бичигтэн / =ижитэн / =фажитан^{Ц.Ш.}] хэмээж ёс үгүй үйлэс бүү үйлэдтүгэй. Үйлдвээс үл аюух уу?!”

... (зарлигийг) бус болгох ард үл айх уу?!

...Бэлэгчин, худалдаачин сэншинүүдийг эрүүтэн болготугай!

...тойдын ёсоор үл явсан, муу үйлс үйлдсэн, худал хулгай хийсэн тойдыг балгадын даргад, ноёдод мэдүүлэгтүн... тэд нар тойдод мэдүүлэн эс чадвал дарга, ноёд гэж байхын хэрэг юун!

...тойдууд харын (буюу төрийн Ц. Ш.) үйлд биднээ уригдаваас иртүгэй, эс уригдваас бүү иртүгэй...”

³ N. Poppe, J. R. Krueger, (1957) *The Mongolian monuments in hPhags-pa script*, Guttinger AF, Band. 8, [147 pp.], p. 79. Wiesbaden.,

гэх мэтээр хуульзүйн үүднээс одоо үгүйлэгдээд байгаа *эрх, үүргийн нэгдэл*-ийг хангасан байдаг. Энэ бүхнээс үзэхэд шашинтан нар хууль ёс зөрчих, тойдын явдалаас гажих, сүм хийд, газар усаа бусдад бэлэглэх, бэлэглэх нэрээр худалдах, худал хулгай хийх, уриагүй байхад төрийн хэрэгт оролцох зэрэг нь цөм тухайн цагийн хууль ёсыг зөрчсөн хэрэгт тооцогдох ажээ.

Шашины талаархи энэ бүх зарлиг цааз нь аливаа улс үндэстэний хамгийн эрхэм зүйлийн нэг болох шашин сурталыг нь эрх тэгш хүндэтгэн үзэж, тэр нь хоосон тунхаг төдий бус Төрийн бодлогын хэмжээнд байж, тэгсэнээрээ амар амгалан аж төрөхийн бас нэгэн үндэс болж ирсэнийг харуулна. Улс төрийн ийм уужуу тайван бодлого орчин үед нэгэнт үгүй болж, Их гүрнүүдийн зүгээс өөр өөрийнхөө шашин суртал, хэл бичиг, соёл уламжлалдаа бусадыг уусган нэгтгэх эрмэлзэл хэтийдсэнээс дэлхий нийтээр нэгэн улсын дотоодод ч, улс ороны хооронд ч элдэв самууны үүд нээгээд байна гэж үзэхэд эрхгүй хүргэж буй... Тухайлбал: Араб бичиг лалын, роман хэмээх латин болон кирилл бичиг христусын... гэх мэтээр бичиг гэдэг зүйлийн цаана чухамдаа шашин суртал явж байдаг бөлгөө. Өөрөөр хэлбэл аливаа улс орны үндэсний бичиг нь уламжлалт шашин сурталынх нь дархлаа болж өгдөг тул бичгийг нь солино гэдэг бол чухамдаа шашин суртал, итгэл бишрэлийг солихын үүдийг нээдэг зүйл бөлгөө.

2. Бичиг үсэгийн тухайд:

Их Юан улсын үед тугдам зохиосон дөрвөлжин бичигийн талаар гарсан Шизү хэмээх Хубилай хааны Жи юаны 6-р он буюу 1269 оны зарлигаас нэлээн олон зүйл тодорхой харагдана⁴. Үүнд:

“... Бичигийн үсгээр үгийг бичиж үйл явдлыг тэмдэглэх буй. Энэ эртнээс эдүгээд хүртэл тогтсон ёс болой... Хэрвээ бичгийг хэрэглэх бөгөөс, эл Хятад улс, Вэй-ү улс [буюу уйгур ^{Ц. III}] улсын бичгээр манай улсын үгийг ухамуй. Дайляо [буюу Хятан ^{Ц. III}] улс, Алтан улс хийгээд аливаа улсыг шинжилвээс өөрийн өөрийн улсын хэлээр бичиг буй ажгуу. Эдүгээ манай улсын хэлээр бичгийн төр [буюу журам ёс ^{Ц. III}]-ийг улам үүсгэх бөгөөтөл бид бичгийг эс хэрэглэвээс төр ёсон маань омтхой болом уу хэмээн зарлиг болоод, тэдүй улсын багш Пагва ламд тушаалгаж, тугдамаар үүсгэн монгол бичиг [энэ тохиолдолд Дөрвөлжин бичиг ^{Ц. III}]-ийг бичүүлэв. Аливаа бичгийг орчуулж бичвээс-бээр үг нь найртай болоод аливаа үйлийн шалтгаан нь тодорхойёо ухагдамуу. Үүнээс хойногиуд тамгын бичиг, тархаах бичгийг монгол хэлээр бичээд, бус улсын бичгийг хослон бичидхүн [бичигтүн ^{Ц. III}]/ хэмээн зарлиг буулгалаа. ...”

хэмээжүхүй.

Үүнээс үзвэл, “... хойногиуд тамгын бичиг, тархаах бичгийг монгол хэлээр бичээд, бус улсын бичгийг хослон бичидхүн!” хэмээсэн нь аливаа албан ёсны зүйлийг дөрвөлжин бичигээр монгол хэлээр бичиж улсын доторхи хятад, уйгур, хятан, зөрчид зэрэг бусад улсын хэл бичигээр хавсарган тархааж байхыг зарлиг болгожээ. Энэ нь тухай тухайн ард түмэний хэл болоод бичигийг эрх тэгш хэрэгсэн хэрэглэх боломжийг буй болгожээ. Нэгэнт үндэсний хэл, бичиг нь тийнхүү зарлиг батлагаатай байх бөгөөс түүгээр дамжин дархлагдсан соёл уламжлал, шашин суртал нь тухайн Төрийн зүгээс

⁴ “Дай Юан улсын бичиг”-ийн Ши-зү хаан Хубилайн бөлөгт буй.

адлагдан мартагдалгүй, хадгалагдсаар байсан гэсэн үг. Гүрэний бүрэлдэхүүн дэхи олон үндэстэний хэл бичиг нь бие даан зэргэцэн хөгжих хууль зүйн эрхтэй байсан гэсэн үг.

Бас нэгэн зүйл: Тэр үед Юан гүрэний бүрэлдэхүүн дэхи монгол, хятад, уйгур, хятан, зөрчид зэрэг олон улс үндэстэн цөм өөр өөрийн бичигтэй байсан бөгөөд монгол ч юмуу, хятад ч юм уу, аль нэгэн зонхилох үндэстэний бэлэн бичигийг улсын бичиг болгох боломж байсан ч монгол дөрвөлжин хэмээх цоо шинэ бичиг зохиосон нь улс төрийн хувьд ухаалиг шийдэл байсан хэрэг. Тэгээд ч эрдэмтэдийн нэрлэсэнээр “13-р зууны олон улсын цагаан толгой” хэмээх тэрхүү шинэ бичигээр гүрэний дотоод дахи бүх улс үндэстэний хэлээр бичих боломжийг буй болгосон нь тэдгээр олон ард түмэний хэл, соёл, уламжлалыг хэвээр хадгалаж, тэдний “сэтгэлийг олсон” нарийн бодлого байсан гэж үзэх бүрэн үндэс буй. Ийм туршлага ойрхи цагийн Их гүрэнүүдийн бодлогод бараг байдаггүй. Жишээ нь: Япончууд Манж го болон Солонгосыг эзлээд сургуульд нь манж, солонгос хэл бичигийн хичээлийн оронд япон хэл бичигийг хүчээр оруулах болсоныг италийн нэрт найруулагч Бернардо Бертолуччи (*Bernardo Bertolucci*)-ийн “Сүүлчийн эзэн хаан” болон Ким Ду-хан гэдэг гол баатартай “Зоригт эрийн түүх” зэрэг киноны баримтаас бэлээхэн харж болно.

Бас нэгэн зүйл: Монгол бичигийг үсэгзүй-авиазүйн үүднээс авч үзвэл мөн монгол туургатаны дотоодод ч үндэстэнийг нэгтгэх тэрхүү зарчим байсаар байсан байсан нь бэлхэнээ харагдана. Тухайлбал: монгол бичигт монгол хэлний нутаг нутагийн аялгуунд сэлгэдэг *а-э, о-у, ө-ү, д-т, х(а)-г(а), х(э)-г(э), ж-й* зэрэг олон авиаг нэгэн үсэгээр тэмдэглэсэн нь зарим нэгэн өөнтөглөгчидийн хэлдэгчилэн монгол бичиг боловсронгуй бусын батлагаа огт биш, *өндөр-үндэр, дашуур- ташуур, халзан-галзан, засах-йасах* гэх мэтээр өөр өөрийнхөө аялгуугаар дуудаж, аль нэгэн зонхилох том аялгуутаны хэлний нөлөөнд авталгүй, унаган аялгуугаа хадгалан, нийт монгол хэл хэмээх нэгэн төв рүү нэгдэн тэмүүлэн нэгдэх (*centripetal*) боломжийг бүрдүүлсээр иржээ. Харин монгол бичигийг “боловсронгуй болгож” тухайн үеийнхээ ярианы хэлэнд ойртуулах гэх зэрэг хэлшинжлэлийн олон шалтгаанаар хожуу зохиосон бараг бүх бичигүүд нь анх зохиогдохдоо цөм нийт монголчуудад зориулсан гэх боловч арга буюу тухайн нутаг дэвсгэртээ нөлөө бүхий аль нэгэн аялгуутаны хүрээнд зориулсан мэт болсоноороо нэгэн төвөөс тусгаарлан салбарлах (*centrifugal*) байдалд санамсаргүй хүргэсэн ажээ. Үүний учир шинэ зохиосон тэдгээр бичигүүд арга буюу тодорхой нэгэн аялгуутаны хүрээнд, цаг хугааны хувьд зарим нь түрхэн зуур хэрэглэгдэгдээд зуурам орхигдоход хүрч арга буюу монгол бичигт байр сууриа тавьж өгсөн хэрэг. Тэгээд ч монгол бичиг нийт монголчуудын дунд цаг хугацааны хувьд анх буй болсоноосоо одоо хүртэл буюу хамагийн урт удаан, орон зайн хувьд бүх монгол туургатаны дунд буюу хамагийн өргөн дэлгэр хэрэглэгдсээр 1940-өөд оныг хүрчээ.

Харин 1941 онд монгол бичигийг мөн л дээрхи мэт шалтгаанаар адлан тайлбарлаж кирилл бичигт шилжсэн нь чухамдаа хэл шинжлэлийн учир холбогдолтой бус, харь гүрэний улс төрийн бодлогоос үүдэлтэй, монгол түмэний соёл уламжлалыг нь таслах, монголчуудыг хэл болон бичигээр нь нэгтгэж байсан монгол бичигийг үгүй болгосоноор монгол туургатаныг задлах далд зорилготой нь холбоотой байлаа. Энэ мэтээр хэлшинжлэл-улс төрийн аливаа шалтага тайлбараар бичигийн хэлийг цаг цагийнхаа ярианы хэлэнд ойртуулах гэж эрмэлзэхийн хэрээр тухайн үгийн язгуур, үндэс, хэлзүйн байх ёстой хэлбэр эвдэрч, монгол хүний эх хэлний унаган мэдрэмжийг аажим аажимаар сааруулахад эрхгүй хүрдэг байна. Бичиг болон ярианы хэл зөрөөтэй байх нь англи, франц, герман зэрэг дэлхийн том том хэлнээ нийтлэг байдаг ерийн

үзэгдэл бөгөөд ярьдагтаа ойртуулан засах гэвэл тухайн үгийн түүхэн хөгжилийн зам чийр бүдгэрэн баларч, үгийн язгуур үндэс эвдэрч, утгын улбаа тасардаг тул тэд нар манайхитай адил засдаггүйн цаад учир тэр бөлгөө.

Тэгээд ч жишээ нь: англи хэлний толь бичигт толгой үг бүрийн ард дөрвөлжин хаалтанд дуудлагыг нь хадаж өгөх болсон нь хэдий төвөгтэй боловч англи хэлний хувьд тухайн үгийн гарал, утгыг хадгалаж, олон нийтийн хэлний унаган мэдрэмжийг нь хадгалсан зөв шийдэл байлаа. Монгол бичигийн хэлний хувьд одоогийн ярианы хэлнээс зөрдөг ч тэр ялгаа нь англи хэл бичигтэй харьцуулахад хамаагүй бага, тэгээд тодорхой тогтолцоотой тул үг бүрийн ард дуудлагыг нь хавсаргах хэмжээнд огт хүрээгүй боловч бид харийн түлхээсээр монгол бичигээ хэрэгцээнээс гаргасан хэрэг.

Үүний дүнд монгол хэлний олон аялгуутан нөлөө бүхий төв халхын аялгуунд уусаж, монгол хэлийг тэтгэх суурь болсоор ирсэн нутаг нутагийнхаа унаган аялгууг гээхийн үүдийг нээжээ. Одоо нутагийнхаа аялгуугаар ярьсан хүнийг элдэвлэн *хөдөө царайт* хэмээн хочлох болжээ. Монголчууд биднийг монголоор нь өдий хүртэл авч ирсэн зүйл бол чухамдаа одоо хоцрогдсонд тооцож буй ч биднийг тэжээсээр ирсэн мал, малчин түмэн гэдгийг бид хэдийнээ мартахад хүрчээ. “*Хоцрогдол*” гэгч мөхөл биш, бид хэрэвзээ дэндүү хөгжсөнгөн бол одоо бидний аархаад байгаа Оюу толгой, Таван толгой, ураны их сан ... маань үгүй байх байлаа, ариг онгон хангай дэлхий ч үгүй байх байлаа... Дээр нь одоо бараг үгүй болж буй монгол хүний мөс аль эрт үгүй болох байлаа ... Уг нь өөд муутай бид эзэн нь болж чадвал өвөг дээдэс маань бидэндээ үлэмж ихийг үлдээжээ.

Дээр өгүүлсэн зүйл хэдийгээр өнгөрсөн үед хамаарах боловч сургамж туршилга нь орчин үеийн олон улсын үйл амьдралд ч хамаагүй биш хэмээн бодож байна. Харамсалтай нь монгол төрийн туршлага одоо нэгэнт үгүй болжээ.

3. Гадаадын эрдэмтэд хэрхэн дүгнэсэн байдаг вэ?

Гэвч Монгол Төрийн бодлого ийм өвөрмөц байсан гэдгийг өнгөрсөн зууны тавиад оноос Европ дахинаа анх профессор В. Котвич (*W. Kotwitz*) дэвшүүлэн гаргаж⁵, түүний мөрөөр олон өгүүлэл, ном гарсаар бөлгөө. Одоо үзвэл зөвхөн Европоор тогтохгүй Ази дахинаа ч үүнийг мэдэж, хэлэх болжээ. Японы Т. Мураока (*T. Muraoka*) профессор 2010 оны намар МОНЦАМЭ-гийн хэвлэлийн төвд ярихдаа:

“...Хубилай хаан Юан гүрнийг байгуулж Бээжинд шилжүүлсэний дараа ч Хархорин Монголын их эзэнт гүрний төв байж цэцэглэн хөгжсөөр байсныг өгүүлсэн. Хархорин хотод тухайн үед зөвхөн бурханы шашин биш олон шашины урсгал байжээ. Монголын эзэнт гүрний түүхийг би цэргийн хүчээр байлдан дагуулж байсан гэж ойлгодог байлаа. Тэгвэл судлагааны ажлын явцад зөвхөн цэргийн хүчээр олон улс орныг нэгтгэж байсан бус олон үндэстэнүүдийг эе эвтэй байлгаж нарийн ухаанаар удирдаж байсан нь батлагдаж байна...”

⁵ W. Kotwicz, (1950) *Les Mongols, promoteur de l'idée de paix universelle au debut du XIIIe siècle*, - *Rocznik Orientalistyczny*, Tom. XVI, Krakow., 1953 – (В. Котвич авгайн төрсөний 100 жилийн ойгоор академич Ринчен багшийнхаа дуртхагсанаар энэ өгүүлэлийн зохиогч уг өгүүлэлийг монголчлон нийтлүүлж билээ: Владислав Котвич, (1974) *XIII зууны эхин үед Монголчууд дэлхий нийтийн энх тайвангийн санааг сэдэж үүсгэсэн нь* // - Хэл зохиол судлал, IX боть, 20-р дэвтэр, 205 - 214 х; Улаанбаатар.,


гэжээ⁶. Хэрэвзээ хүрч судлаж чадаж гэмээ нь ийм дүгнэлт аяндаа гарч л таарна. Гадаадын эрдэмтэд ийнхүү олж хараад байхад манай түүхчид энэ талаар бараг ам ангайхгүй байгааг нь их гүрнүүдийн боловсруулсан хоосон онолд хэт шүтэж, тухайн баримтыг агуулсан монгол хэлээрхи монгол, дөрвөлжин, тод бичгийн дурсгал, хятад, төвөд, перс, армян, араб, латин зэрэг бусад хэл бичгээрхи түүхэн сурвалжийг олж үздэггүй, дотоод гадаадын олон монголч эрдэмтэн мэддэг бичгээр нь галиглан буулгаж, эдүгээчлэн орчуулж бэлэн хоолыг нь бэлтгэсээр атал анзааран хайхардаггүйтэй нь холбоотой гэж “цагаатгах”-аас...

(Юан гүрэний үеийн хаадын монгол болон дөрвөлжин бичгээрх хоёр зарлигийг хятад хүнд ойлгомжтой болгохын үүднээс хадмал орчуулгынхи нь хамт үлгэр болгож ард хавсарган толилуулав⁷)


⁶ МОНЦАМЭ мэдээ. (2010. 8. 24) *Нүүдэлчдийн бичиг үсгийн шинэ дурсгалууд олдлоо*, - No. 162 (2020), 11-р нүүр (Булан: Түүх соёл). Улаанбаатар.,

⁷ [中国少林寺 (Zhongguo Shaolin si), (2005) Volume 1-3, (Zhonghua Shuju), ISBN 710 10 38999, See Vol. 2, pp. 84-85.]


1-P ХАВСРАЛТ




Хубилай хааны монгол бичгээрхи луу (1268) жилийн зарлиг



Хубилай хааны луу (1268) жилийн зарлигийн хятад хадмал орчуулга



Буянт хааны дөрвөлжин бичгээрх хулгана (1312) жилийн зарлиг



Буянт хааны хулгана (1312) жилийн зарлигийн хятад хадмал орчуулга

РЕЗЮМЕ

Автор в данной статье критически рассматривает некоторые современные политические события, которые имели отрицательный эффект на мировое сообщество в целом. Далее автор излагает исторические факты, свидетельствующие о политике лояльного отношения Монгольской империи не только по отношению к завоеванным элитам, но и об уважительном отношении к чужой культуре, религии, письменности. Автор особо подчеркивает то, что в настоящее время, несмотря на многочисленные публикации исторических источников, переведенных со старописьменного монгольского, квадратного, ясного письма, а также с китайского, персидского, армянского, арабского, латинского языков, исследователи до сих пор недостаточно активно пользуются ими.